

4. Шуухэд дуудагдсан иргэн урилгыг заавал датах шаардлагагүй. Зарлан дуудах хуудсаар дуудагдсан этгээд хэрэв ирэхгүй бол туунд албадлагын арга хэрэглэж болохгүй.

Далдугаар зүйл

Даалгавар хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн нутаг дэвсгэрт хоригдож байгаа хүнийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн шуухэд гэрч буюу шинжээчийн хувьд байцаах зорилгоор тур ируулэхээр дуудсан бол шуухийн тэр даалгаврын хувьд энэхуу Гэрээний 68 дугаар зүйлийг баримтална.

Далан нэгдүгээр зүйл

Эруугийн хэрэг уусгэх уурзг

1. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд аль нэгнийхээ шаардлагаар Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт энэхуу Гэрээний 74 дүгээр зүйлд зааснаар шилжуулэн өгч болох эруугийн гэмт хэрэг уйлдсэн өөрийн харьяатад дотоодын хууль тогтоомжийк дагуу эруугийн хэрэг уусгэж байх уурэг тус тусдаа хүлээнэ.

2. Эруугийн хэрэг уусгэх тухай шаардлагад урьдчилсан мөрдөн байцаалтын дун, гэмт хэрэг уйлдсэн тухай бусад нотлох баримтыг хавсаргана.

3. Хусэлт хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд эруугийн хэрэг уусгэсэн дунгийн тухай Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдэд мэдэгдэх уурэгтэй. Хэрэв уг хэргийг таслан шийдвэрлэсэн тогтоол хүчин төгөлдөр болсон бол тууний хувийг мэдэгдэлд хавсаргана.